



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УУЛ УУРХАЙН ХҮРЭЭЛЭНГИЙН 2017 ОНЫ ЖИЛИЙН
ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТ

Аудитын код: **САГ-2018/199/СТА-ТШЗ**

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**



Аудитын код: САГ-2018/199/СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Аудитор Д.Цэгмиддорж
Утас: 261740 Цахим хаяг: tsegmiddorjd@audit.gov.mn

Монгол улс “Баян суварга аудит” ХХК-ийн Захирал С.Должинсүрэн

Утас:99126723
Цахим хаяг: doljinsuren9@yahoo.com

Аудитор: Х.Тунгалагтуяа


Утас: 99176599
Цахим хаяг: h.tungalagtuya@yahoo.com

Туслах аудитор: Ц.Эрдэнэчулуун

Утас: 94080717
Цахим хаяг: tserdenechuluun@yahoo.com



Улаанбаатар хот



АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	1
2	Аудитын тайлан	3
	2.1 Оршил	3
	2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	3
	2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	4
	2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	4
	2.5 Дотоод хяналт	4
	2.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	5
	2.7 Шилэн дансны мэдээлэл	5
	2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	5
	2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	5
	2.9.1 Авлага, өр төлбөрийн талаар	5
	2.9.2 Төсвийн орлогын талаар	6
	2.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал	6
	2.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	6
	2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	6
	2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	7
	2.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
	2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	7
3	Менежментийн захидал	8
	3.1 Авлага өр төлбөрийн талаар	9
	3.2 Төсвийн орлогын талаар	10
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	11
	4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	13
	4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	14
	4.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	15
	4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
	4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	17

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

01
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ



УУЛ УУРХАЙН ХҮРЭЭЛЭНГИЙН
ЗАХИРАЛ Х.ЖАРГАЛСАЙХАН ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2018.02.23 № 06/487
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Уул уурхайн хүрээлэнгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Уул уурхайн хүрээлэнгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Уул уурхайн хүрээлэнгийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нөхцөл бүхий алттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

01

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2018.02.23 № 06/487
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Уул уурхайн хүрээлэнгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Уул уурхайн хүрээлэнгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Уул уурхайн хүрээлэнгийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

01

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Уул уурхайн хүрээлэнгийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Уул уурхайн хүрээлэнгийн Захирал Х.Жаргалсайхан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасаншийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулах, зардлыг төсөвлөх, авлагыгтооцоо нийлж баталгаажуулах, үндсэн үйл ажиллагааны орлогыг бүрэнтайлагнах, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Уул уурхайн хүрээлэнгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.



Уул уурхайн хүрээлэнгийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитойн аудит үрээний УУЛЛАГА

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Уул уурхайн хүрээлэнгийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитыг 2018 оны 2 дугаар сарын 05-наас 2 дугаар сарын 15-ны хооронд хийхээр төлөвлөн "Баян суварга Аудит" ХХК-ийн аудитор Х.Тунгалагтуяа, туслах аудитор Ц.Эрдэнэчулуун нар хэрэгжүүлж ажиллав.

Уул уурхайн хүрээлэнгийн 2017 оны санхүүгийн тайланг 2018 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.



2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Уул уурхайн хүрээлэн санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал, “Эдийн засгийн ангилал батлах тухай” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Уул уурхайн хүрээлэн нь Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 21 дүгээр тогтоолын дагуу төрийн өмчит байгууллага болон ТИС-ийн харъяалалд шилжиж, захирлын 1997 оны 139 дүгээр тушаалаар байгуулагдаж хяналт шинжилгээний лаборатори, захиргаа аж ахуйн нэгжтэйгээр 20 орон тооны бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Тус хүрээлэн улс орны нийгэм эдийн засгийн хөгжлийн тулгуур уул уурхайн салбарт эрдэм шинжилгээ, төсөл судалгаа, үйлдвэр-туршилтын мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх, хариуцлагатай, аюулгүй, хүний эрүүл мэндэд халгүй, байгаль орчинд ээлтэй, харилцан ашигтай, хуулиа дээдэлсэн зарчмыг баримтлан уул уурхайн салбарын үйлдвэрлэлийг эрчимжүүлэх зорилготой ажиллаж байна.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000–1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Уул уурхайн хүрээлэнгийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Гүйцэтгэлийн шатанд санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан 30 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Материаллаг байдлын түвшингийн суурийг тус байгууллагын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар тооцож 8,422.3 мянган төгрөгөөр тогтоосон болно. /ТАБ-СТА-В1/

Тус хүрээлэн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг “Acolous 3.0” програмаар боловсруулан санхүүгийн тайлан, аудитын үйл ажиллагааны дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Уул уурхайн хүрээлэнгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

2.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу хүрээлэнгийн Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг

01

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

боловсруулан, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангаж, төсвийг зардлын зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Уул уурхайн хүрээлэнгийн 2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу БСШУСЯ-ны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

Уул уурхайн хүрээлэн 2017 онд нийт 253,876.8 мянган төгрөгийн батлагдсан төсөвтэй, гүйцэтгэлээр нийт 253,106.9 мянган төгрөг зарцуулж, 769.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

БСШУ-ны сайдын 2017 оны А/34 дүгээр тушаалаар тус хүрээлэнгийн төслөөс олох нэмэлт орлого, зардлын төсвийг нийт 273,000.0 мянган төгрөгөөр баталсан боловч хүрээлэн 2017 онд 159,314.7 мянган төгрөгийн орлого олж бүрэн зарцуулсан байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Уул уурхайн хүрээлэн нь Шилэн дансны хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр оруулах мэдээллийг оруулсан байна.

БСШУСЯ-ны шилэн дансны цахим хуудас /www.shilendans.gov.mn/-т тус хүрээлэнгийн нэрээр нэвтрэн байгууллагын тухайн жилийн төсөв, гүйцэтгэл, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, санхүүжилт, бараа, ажил үйлчилгээ худалдан авсан нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг мэдээллийг оруулсан.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 24 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Аудитын явцад Уул уурхайн хүрээлэнд мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, дансны болон ерөнхий журнал, ерөнхий дэвтэр зэрэг хураангуй бичигтийг арга зүйн хуульд нягтлан үзэж санхүүгийн тайлангийн илэрхийлэлд үнэлэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.9.1 Авлага, өр төлбөрийн талаар

2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд өмнөх онуудаас уламжлагдаж ирсэн нэр бүхий 5 байгууллагатай холбоотой нийт 123,669.6 мянган төгрөгийн авлага, 100,6 мянган төгрөгийн өглөгийн ХХОАТ-ыг бүртгэж тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасантай нийцэхгүй байна.

01

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дугаар заалтыг хэрэгжүүлж, авлага, өр төлбөрийн тайлан тооцоонд бүртгэлээр тавих дотоод хяналтыг сайжруулж ажиллахыг хүрээлэнгийн удирдлагад зөвлөмж болгох.

2.9.2 Үндсэн хөрөнгийн талаар

Тус хүрээлэнгийн үндсэн хөрөнгийн дансанд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртөгөө бүрэн нөхсөн Пажеро маркийн суудлын авто машин бүртгэгдэж байгаа бөгөөд уг автомашиныг 2005 онд 11,500.0 мянган төгрөгөөр худалдан авч, 2012 онд дахин үнэлгээр 17,250.0 мянган төгрөгөөр үнэлэн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Уг авто машины ашиглалтын талаар ТӨБЗГ-тай зөвшилцөн шийдвэрлэх талаар хүрээлэнгийн удирдлагад анхааруулав.

2.9.3 Төсвийн орлогын талаар

Тус хүрээлэнгийн 2017 оны нэмэлт санхүүжилтын төсвийн орлогыг 273,000.0 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 159,314,6 мянган төгрөгийн орлого олж, 113,685.5 мянган төгрөгөөр тасарсан байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн нэмэлт орлогын төлөвлөлтийг тооцоо судалгаан дээр хийж үндэслэлтэй төлөвлөж, төсвийг зохистой удирдаж ажиллахыг хүрээлэнгийн удирдлагад зөвлөмж болгох.

2.9.4 Санхүүгийн тайлан гаргалтын талаар

Уул уурхайн хүрээлэн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан хугацаанаас 1 хоногоор хоцроож буюу 2018 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр Үндэсний аудитын газарт ирүүлсэн.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасныг хэрэгжүүлж, санхүүгийн тайлан тооцоонд тавих дотоод хяналтыг сайжруулж ажиллахыг хүрээлэнгийн удирдлагад анхааруулав.

2.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй болно.

2.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд


Уул уурхайн хүрээлэнгийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгаж дүгнэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Уул уурхайн хүрээлэнгийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар нийт 237,455.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба дээрх зөрчлийг гаргахгүй байх талаар удирдлагын анхааралд хандуулж 2 зөвлөмж өгсөн болно.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Уул уурхайн хүрээлэнгийн 2016 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газраас аудитын түүврийн сорилд хамруулсан бөгөөд бие даасан зөвлөмж өгөөгүй байна.



2.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Материаллаг байдлын түвшингийн суурийг тус байгууллагын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар тооцож 8,422.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Уул уурхайн хүрээлэнгийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Аудитын явцад хийсэн сорилын үр дүнд санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлүүдтэй зөрчилдсөн материаллаг хэмжээний алдаа, зөрчилтэй дараах асуудлууд илэрсэн болно. Үүнд:

- Уул уурхайн хүрээлэн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан хугацаанаас 1 хоногоор хоцроож буюу 2018 оны 01 дугаар сарын 26-ны өдөр Үндэсний аудитын газарт ирүүлсэн,
- 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд нийт 123,669.6 мянган төгрөгийн авлагыг бүртгэж тайлагнасан, үүнээс нэр бүхий 3 байгууллагаас авах 23,069.6 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй,
- Тус хүрээлэнгийн 2017 оны нэмэлт санхүүжилтын төсвийн орлогыг 273,000.0 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 159,314.6 мянган төгрөгийн орлого олж, төлөвлөгөөг 58.4 хувь буюу 113,685.5 мянган төгрөгөөр тасалсан байна.

Энэ нь УСНББОУС болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцээгүй байна.

Иймд дээр дурдсан алдаа зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллийг эс тооцвол Уул уурхайн хүрээлэнгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

3 Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Уул уурхайн хүрээлэнгийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

ҮАГ-ын ажиглалт

2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайландөмнөх онуудаас уламжлагдаж ирсэн нэр бүхий 5 байгууллагатай холбоотой нийт123,669.6 мянган төгрөгийн авлага болон ХХОАТ-ын өглөгийн 100.6 мянган төгрөгийг бүртгэж тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасантай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Авлага, өр төлбөрийн тайлан тооцоонд бүртгэлээр тавих хяналт суларч, хууль эрхийн акт зөрчигдөх, найдваргүй авлага үүсэх.

ҮАГ-ын зөвлөмжүүд

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дугаар заалтыг хэрэгжүүлж, авлага, өр төлбөрийн тайлан тооцоонд бүртгэлээр тавих дотоод хяналтыг сайжруулж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

ҮАГ-ын ажиглалт

Тус хүрээлэнгийн 2017 оны нэмэлт санхүүжилтын төсвийн орлогыг 273,000.0 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 159,314,6 мянган төгрөгийн орлого олж, 113,685.5 мянган төгрөгөөр тасарсан байна.

ҮАГ-ын зөвлөмжүүд

Төсвийн нэмэлт орлогын төлөвлөлтийг тооцоо судалгаатай, үндэслэлтэй төлөвлөж, төсвийг зохистой удирдаж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэлүүд

Төсвийн хууль зөрчигдөх, санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд ташаа мэдээлэл өгөх .

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

ҮАГ-ын ажиглалт

Уул уурхайн хүрээлэн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан хугацаанаас 1 хоногоор хоцроож буюу 2018 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр Үндэсний аудитын газарт ирүүлсэн

ҮАГ-ын зөвлөмжүүд

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасныг хэрэгжүүлж, санхүүгийн тайлан тооцоонд тавих дотоод хяналтыг сайжруулж ажиллахыг хүрээлэнгийн удирдлагад анхааруулав. 2018 оны 7-р сарын 1 ны дотор.

Эрсдэлүүд

Хууль зөрчих эрсдэлтэй.

Үйлчлүүлэгчийн хариу

Зөвлөмжийн дагуу цаг хугацаанд нь тасралтгүй бэлтгэн хүргэж байна.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

4. Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

4.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	203,975,320.01	133,569,600.01
32	АВЛАГА	203,925,320.01	123,669,600.01
33100	Төлбөртэй үйлчилгээний авлага	85,400,000.00	47,000,000.00
325	Бусад авлага	118,575,320.01	76,669,600.01
3251	Байгууллагаас авах авлага	118,575,320.01	76,669,600.01
33	УРЬДЧИЛГАА		9,900,000.00
33100	Урьдчилж гарсан зардал		9,900,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	626,668,078.96	568,643,919.42
34	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	626,668,078.96	568,643,919.42
392	Биет хөрөнгө	604,628,942.80	553,129,616.26
39201	Барилга, байгууламж, орон сууц	51,138,500.00	51,138,500.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(6,416,277.79)	(8,082,944.47)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	17,250,000.00	17,250,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(17,250,000.00)	(17,250,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	727,680,875.00	710,567,715.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(185,259,630.25)	(215,819,220.23)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	48,192,120.00	45,354,780.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(36,176,867.01)	(35,499,436.89)
39209	Номын фонд	5,470,222.85	5,470,222.85
393	Биет бус хөрөнгө	22,039,136.16	15,514,303.16
39301	Програм хангамж	46,167,892.00	45,167,892.00
39302	Хасагдуулга	(24,128,755.84)	(29,653,588.84)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	830,643,398.97	702,213,519.43
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	52,249.99	100,580.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	52,249.99	100,580.00
411	Өглөг	52,249.99	100,580.00
41110	Ажилчидтай холбогдсон өглөг	52,249.99	100,580.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	830,591,148.98	702,112,939.43
51	Засгийн газрын хувь оролцоо	830,591,148.98	702,112,939.43
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	151,495,662.82	151,495,662.82
51101	Өмч: - төрийн	151,495,662.82	151,495,662.82
512	Хуримтлагдсан үр дүн	662,580,199.16	534,101,989.61
51210	Өмнөх үеийн үр дүн	662,580,199.16	662,580,199.16
51220	Тайлант үеийн үр дүн		(128,478,209.55)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	16,515,287.00	16,515,287.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	830,643,398.97	702,213,519.43

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	388,602,200.00	332,726,060.52
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	388,602,200.00	332,726,060.52
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	247,334,700.00	253,786,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	247,334,700.00	253,786,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	141,267,500.00	78,939,360.52
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	138,780,000.00	78,939,360.52
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	443,461,735.48	461,204,270.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	440,641,814.48	454,434,363.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	440,641,814.48	454,434,363.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	216,102,378.00	194,434,938.81
210101	Үндсэн цалин	216,102,378.00	194,434,938.81
210102	Нэмэгдэл		
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,484,381.99	21,963,265.26
210201	Тэтгэврийн даатгал	15,201,227.99	14,789,757.26
210202	Тэтгэмжийн даатгал	1,735,603.00	1,555,480.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,169,504.00	1,944,349.00
210204	Ажилгүйдлийн даатгал	398,005.00	333,970.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,980,042.00	3,339,709.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,460,128.00	38,850,000.00
210304	Байрны түрээс	40,460,128.00	38,850,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,988,435.58	5,846,500.00
210401	Бичиг хэрэг	1,331,254.58	3,411,400.00
210402	Тээвэр, шатахуун		110,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,112,000.00	2,225,000.00
210404	Ном, хэвлэл	1,305,000.00	100,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	200,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	40,181.00	
2105	Нормативт зардал	272,700.00	500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	272,700.00	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	8,156,400.00	1,336,221.00
210701	Гадаад албан томилолт	4,156,400.00	1,336,221.00
210702	Дотоод албан томилолт	4,000,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	84,498,201.00	133,479,279.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	84,498,201.00	133,479,279.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	61,879,189.91	58,024,159.54
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,190,020.06	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	180,000.00	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	60,309,169.91	58,024,159.54
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,819,921.00	1,909,906.46
2132	Бусад урсгал шилжүүлэг		6,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	6,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,819,921.00	769,906.46
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,819,921.00	769,906.46
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	(54,859,535.48)	(128,478,209.55)
5	НИЙТ ҮР ДҮН	(54,859,535.48)	(128,478,209.55)

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛДАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

4.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	151,495,662.82	16,515,287.00	717,439,734.64		885,450,684.46
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	151,495,662.82	16,515,287.00	717,439,734.64	0	885,450,684.46
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн			(54,859,535.48)		(54,859,535.48)
C08	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл		0		0	
D01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	151,495,662.82	16,515,287.00	662,580,199.16	0	830,591,148.98
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Дахин илэрхийлсэн дүн	151,495,662.82	16,515,287.00	662,580,199.16		830,591,148.98
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			(128,478,209.55)		(128,478,209.55)
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	151,495,662.82	16,515,287.00	534,101,989.61	0	702,112,939.43

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Төлбөрийн код	Зориулалт, арга хэмжээний код	Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны			Хувь
				Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
		1							
71805	80101		Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл						
71805	80101	2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН			253,073,552.70	253,073,552.70	2,989,747.30	98.83
71805	80101	21	УРСГАЛ ЗАРДАЛ			256,063,300.00	256,063,300.00	2,989,747.30	98.83
71805	80101	210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ			250,063,300.00	247,073,552.70	2,989,747.30	98.80
71805	80101	2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		0.00	176,330,400.00	175,210,273.53	1,120,126.47	99.36
71805	80101	210101	Үндсэн цалин		0.00	176,330,400.00	175,210,273.00	1,120,127.00	99.36
71805	80101	2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		0.00	21,532,900.00	19,963,279.00	1,569,621.00	92.71
71805	80101	210201	Тэтгэврийн даатгал			13,032,927.28	12,703,904.93	329,022.35	97.48
71805	80101	210202	Тэтгэмжийн даатгал			1,279,309.09	1,451,874.84	-172,565.75	113.49
71805	80101	210203	ҮОМШӨ-ний даатгал			1,590,518.18	1,660,850.66	-70,332.48	104.42
71805	80101	210204	Ажилгүйдлийн даатгал			618,209.09	516,967.61	101,241.48	83.62
71805	80101	210205	Эрүүл мэндийн даатгал			5,011,936.36	3,629,681.13	1,382,255.23	72.42
71805	80101	2103	Байршиглалттай холбоотой тогтмол зардал		0.00	38,850,000.00	38,850,000.00	0.00	100.00
71805	80101	210301	Байрны түрээс			38,850,000.00	38,850,000.00	0.00	100.00
71805	80101	2104	Хангамж, бараа материалын зардал		0.00	1,950,000.00	1,650,000.00	300,000.00	84.62
71805	80101	210401	Бяцг хэрэг			150,000.00	75,000.00	75,000.00	50.00
71805	80101	210402	Шуудан, холбоо, интернэгийн төлбөр			1,800,000.00	1,575,000.00	225,000.00	87.50
71805	80101	2105	Норматив зардал		0.00	500,000.00	500,000.00	0.00	100.00
71805	80101	210501	Нотомын хувцас, зөөлөн эдлэл			500,000.00	500,000.00	0.00	100.00
71805	80101	2106	Томилголт, зочны зардал		0.00	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.00
71805	80101	210601	Дотоод албан томилолт			1,000,000.00	1,000,000.00	0.00	100.00
71805	80101	2107	Уусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		0.00	9,900,000.00	9,900,000.00	0.00	100.00
71805	80101	210701	Уусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж			9,900,000.00	9,900,000.00	0.00	100.00
71805	80101	213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ			6,000,000.00	6,000,000.00	0.00	100.00
71805	80101	2131	Урсгалын газрын урсгал шилжүүлэг			6,000,000.00	6,000,000.00	0.00	100.00
71805	80101	2132	Бусад урсгал шилжүүлэг		0.00	6,000,000.00	6,000,000.00	0.00	100.00
71805	80101	213209	Бусад урсгал шилжүүлэг			6,000,000.00	6,000,000.00	0.00	100.00
71805	80101	1310	Бэлтгэл, үлдэгдлийн тэтгэмж, шагналын урамшуулал			255,286,700.00	253,073,552.70	2,213,147.30	99.13
71805	80101	131001	ЗАРДАЛЫН САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		0.00	253,786,700.00	253,073,552.70	713,147.30	99.72
71805	80101	120004	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		0.00	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.00
71805	80101	1200041	Улсын төсвөөс санхүүжих		0.00	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.00
71805	80101	1200041	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		0.00	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.00
71805	80101	1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих			1,500,000.00	1,500,000.00	0.00	100.00

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг

Бага тойруу-3, Засгийн газрын IV байр

